

**НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ТЭРГҮҮЛЭГЧИД ТҮҮНИЙ АЖЛЫН АЛБАНААС 2019 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭЛЭЛ**

/2019.01.01 - 2019.12.05/

2019 оны 12 дугаар сарын 05

Улаанбаатар хот

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчид түүний Ажлын алба хууль тогтоомж, дээд газрын тогтоол, шийдвэр, өөрийн хурал, Тэргүүлэгчдээс дэвшүүлсэн бодлого, зорилтыг хэрэгжүүлэх, иргэдийнхээ хөгжлийг дэмжих жилийн хүрээнд бодитой, үр дүн бүхий арга хэмжээ зохион байгуулахад анхаарч, үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа.

Тайлант онд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчид түүний Ажлын албанаас 2019 онд Хурал, Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэх асуудал, Хурлын хороод, Ажлын албанаас зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөө, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах, Авлигатай тэмцэх байгууллагын төлөвлөгөө, Гадаад, дотоод харилцаа, хамтын ажиллагаа, Хэвлэл мэдээлэл, мэдээллийн ил тод байдлыг хангах, Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдийг тус тус боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг хагас, бүтэн жилээр тооцон ажиллалаа.

Хурлын үндсэн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурлын хуралдаан бөгөөд Хурлын чөлөөт цагт бүрэн эрхийг нь хэрэгжүүлэгч Хурлын Тэргүүлэгчид тайлант онд дүүргийн Засаг даргаас өргөн барьсан 28, Хурлын Ажлын албанаас өргөн мэдүүлсэн 29 асуудлын хүрээнд ээлжит бус 1, ээлжит 13, нийт 14 удаа хуралдаж, 46 тогтоол шийдвэр баталсан байна.

Хурлын Тэргүүлэгчдээс баталсан шийдвэрийг ангилвал:

1. Дүрэм журам:

- Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /Гудамж, байрны нийтийн эргүүлийн урамшуулал/
- Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Шагналын журам шинэчлэн батлах тухай
- Хурлын Ажлын албаны хөдөлмөрийн дотоод журам шинэчлэн батлах тухай

2. Зохион байгуулалтын чиглэлээр:

- Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2019 онд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай
- Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд иргэдийг оролцуулах тухай
- Үүрэг болгох тухай
- Хуралдааны тов зарлах тухай

3. Шагнал, урамшууллын чиглэлээр:

- Төрийн цол одон медалиар шагнуулахаар уламжлах тухай

- Алдарт эх 1,2 дугаар одонгоор шагнуулахаар уламжлах тухай
- Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналаар шагнах тухай
- Хурлын Төлөөлөгчдөд урамшуулал олгох тухай
- Ахмад настанд ээлтэй байгууллага, иргэнийг шалгаруулж, шагнах тухай

4. Өмч, хөрөнгийн чиглэлээр:

- Хөрөнгө шилжүүлэх тухай

5. Эрх зөвшөөрөл олгох чиглэлээр:

- Ой тэмдэглэх зөвшөөрөл олгох тухай
- Буцалтгүй тусламж олгох тухай зэрэг шийдвэр тус тус болно.

Хурлын Тэргүүлэгчид хяналт шалгалтын чиглэлээр:

- Дүүргийн гадаад бодлогын баримт бичгийн хэрэгжилт
- Ногоон дүүрэг
- Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааг хангах
- Гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагааг дүүргийн хэмжээнд зохион байгуулах гамшиг осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх
- Эрүүл мэнд -2020
- Чингэлтэйн боловсрол-2020
- Жаргалтай гэр бүл
- Хотын иргэн- хотын соёл
- Хамтдаа хөгжье
- Чингэлтэйд үйлдвэрлэв хөтөлбөрүүдийн хэрэгжилт болон өмч хөрөнгө, хөрөнгө оруулалтын ажлын явц, татвар болон газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх тайлан, мэдээг сонсож дүүргийн Засаг даргад 17 заалт бүхий үүрэг, чиглэлийг тэмдэглэлээр өгч, 10 заалт бүхий үүрэг, чиглэлийг дүүргийн Засаг даргад, 4 заалт бүхий үүрэг, чиглэлийг тогтоолоор дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх хэлтэс, албадад тус тус хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажиллалаа.

Хурлын Тэргүүлэгчдээс баталсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхэд 90-100 хувь буюу бүрэн хангалттай биелэгдсэн-41, 50-89 хувь буюу хэрэгжих шатандаа-5 байна.

Хурал нь хуралдаанаар хэлэлцэх асуудлыг урьдчилан бэлтгэх, санал, дүгнэлт гаргах, Хурлын тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан шалгах чиг үүрэг бүхий Хурлын хороог ажиллуулж, 2019 онд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 09 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд Хурлын даргын баталсан удирдамжийн дагуу Хурлын хороод нийт 21 удаа хуралдснаас; Эрх зүй, нутгийн удирдлагын хороо 3, Эдийн засаг, төсвийн хороо 2, Төсвийн зарцуулалтын хяналтын хороо 3, Ногоон хөгжил, газрын харилцааны хороо 4, Хот байгуулалт,

үйлдвэрлэл үйлчилгээ, гэр хорооллын хөгжлийн хороо 3, Нийгмийн хөгжлийн хороо 4, Ёс зүй, өргөдлийн хороо 2 удаа тус тус хуралдаж, танилцсан ажлын чиглэлээр санал дүгнэлт боловсруулан Хурал, Тэргүүлэгчдэд танилцуулсан байна.

Хурлын хороод эрхлэх асуудлын хүрээнд хяналт шалгалтын чиглэлээр дараах бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт болон хэрэгжүүлж буй ажлуудын явц байдал, гүйцэтгэлтэй танилцсан байна. Үүнд:

Эрх зүй, нутгийн удирдлагын хороо:

- Дүүргийн Гадаад бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үйл ажиллагааны явц;
- Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагааны явц;
- Гамшгаас хамгаалах сайн дурын үйл ажиллагааг дүүргийн хэмжээнд зохион байгуулах гамшиг осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагааны явц;
- Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт, 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл /харьяалах асуудлаар/
- Олон Улсын Хүний эрхийн өдрийг тохиолдуулан уламжлал болгон зохион байгуулдаг “Мэтгэлцээний дүүргийн аварга шалгаруулах тэмцээн-2019”;

Эдийн засаг, төсвийн хороо:

- Дүүргийн Татварын төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт;
- Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт, 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл /харьяалах асуудлаар/
- Дүүргийн 2020 оны төсвийн төсөл;

Төсвийн зарцуулалтын хяналтын хороо:

- Дүүргийн 2018 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын дүн, орон нутгийн өмчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын талаар хийж байгаа ажлын танилцуулга, Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар /Ахмадын амралтын газрууд/ төрийн өмч хөрөнгийн ашиглалт, санхүүгийн гүйцэтгэл;
- Дүүргийн Худалдан авах ажиллагааны албанаас хийсэн дүүргийн хөрөнгө оруулалт болон Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хийж хэрэгжүүлэх ажлын талаарх мэдээлэл;
- Дүүргийн Засаг даргын нөөц, нийгмийн халамжийн сангийн хөрөнгө, дүүргийн хэмжээнд хэрэгжүүлж буй 9 хөтөлбөр болон Засаг даргын Тамгын газрын санхүү, төсвийн зарцуулалт;
- Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт болон дүүргийн төсвийн зарцуулалттай холбоотой байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт;

- Мэдээллийн ил тод байдал, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, 2019 оны төсвийн төлөвлөгөө, санхүүгийн гүйцэтгэлийн мэдээг www.shilendans.gov.mn сайтад хуваарийн дагуу байршуулж байгаа эсэхэд хяналт тавих, санал дүгнэлт боловсруулах;
- Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт, 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл /харьяалах асуудлаар/
- Дүүргийн 2018 оны төсвийн гүйцэтгэл;

Ногоон хөгжил, газрын харилцааны хороо:

- Сууц өмчлөгчдийн холбооны газар эзэмшлийн талаар хийж хэрэгжүүлсэн ажлын явц;
- “Агаар орчны бохирдол хүний эрүүл мэндэд нөлөөлөх” сэдэвт сургалт, үйл ажиллагаа;
- “Ногоон дүүрэг” хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагааны явц;
- Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт, 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл /харьяалах асуудлаар/;
- Дүүргийн газар зохион байгуулалтын 2019 оны төлөвлөгөөний хэрэгжилт, 2020 оны төлөвлөгөөний төсөл;

Хот байгуулалт, үйлдвэрлэл үйлчилгээ, гэр хорооллын хөгжлийн хороо

- Хогны менежмент, гэрэлтүүлэг, камержуулалтын талаар хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагаа;
- Тохижилт үйлчилгээний компани, “Соён дрийм” ХХК-ний үйл ажиллагаа;
- Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, үйл ажиллагааны чиглэлээр холбогдох хэлтсүүдээс мэдээлэл авах, санал солилцох;
- Зөөврийн ажлын байрны үйл ажиллагааны талаар холбогдох хэлтсүүдээс мэдээлэл авах, санал солилцох;
- Сэлбэ дэд төвийн хүрээнд дүүргийн 18 дугаар хороонд хийгдэж байгаа Зам инженерийн шугам сүлжээ, дулааны станц, Цэцэрлэг, Мэргэжлийн сургалт үйлдвэрийн төвийн явц байдал;
- 14 дүгээр хороонд баригдаж буй “Яаралтай түргэн тусламжийн пункт”-ийн явц байдал;
- 7 дугаар хороонд баригдаж буй хэсэгчилсэн болон бие даасан инженерийн шийдэл бүхий “Сервис центр” буюу дэд бүтцийн төвийн үйл ажиллагаа болон айл өрхүүдийн шугам сүлжээний холболт, цэвэрлэх байгууламжийн угсралтын ажлын явц байдал;
- “Чингэлтэйд үйлдвэрлэл” хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагааны явц;
- Дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2019 оны хэрэгжилт, 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл /харьяалах асуудлаар/

Нийгмийн хөгжлийн хороо

- Нийгмийн хөгжлийн хорооны нэрэмжит өдөрлөг;
- 7, 14 дүгээр хороодын Биеийн тамир, спортын цогцолборын үйл явц;
- “Эрүүл мэнд-2020” хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагааны явц;
- “Чингэлтэйн боловсрол-2020” хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагааны явц;
- “Жаргалтай гэр бүл” хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагааны явц;
- “Хотын иргэн-Хотын соёл” хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагааны явц;
- “Хамтдаа хөгжье” хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагааны явц;
- Дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2019 оны хэрэгжилт, 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл /харьяалах асуудлаар/

Ёс зүй, өргөдлийн хороо

- Засаг даргын Тамгын газарт байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явц, Тамгын газрын ёс зүйн зөвлөлийн ажлын тайлан;
- Засаг даргын Тамгын газар болон хороодын албан хаагчидтай холбоотой байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт;
- Дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2019 оны хэрэгжилт, 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл /харьяалах асуудлаар/

Тайлант онд Хурлын хороодоос эрхэлсэн асуудлынхаа хүрээнд хяналт шалгалт хийж санал дүгнэлт, зохистой шийдлийн төсөл боловсруулж шийдвэрлүүлэх хүрээнд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан 7 хорооны 41 ажлыг зохион байгуулахаар 9 удаагийн удирдамж, төлөвлөгөө батлуулан, 38 ажлыг бүрэн зохион байгуулж, цаг үеийн шалтгаанаар 3 ажил хойшилж, биелэлт 92,6 хувьтай байна.

Хурлын Төлөөлөгчдийн иргэд, сонгогчидтойгоо ажиллах нөхцөлийг бүрдүүлж, бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх хүрээнд: “Чингэлтэй бидний хайрхан”, “Ээждээ илгээх сэтгэлийн үг”, “Эрүүл агаар эм-идэвхтэй хөдөлгөөн”, “Даатгал бидний ирээдүй”, “Ёслолтой бүртгэл”, “Сэтгэлийн бэлэг” “Эх орон тусгаар тогтнолын үнэ цэнэ” сэдэвт нийт 7 удаагийн үйл ажиллагаанд, Үндсэн хуулийн өдрийн арга хэмжээ, Сар шинэ нэгдсэн арга хэмжээ, Ахмад настанд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ, Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээ, Хичээлийн шинэ жилийн нээлтийн арга хэмжээ, Улс Төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдрийн арга хэмжээ, Хөнгөн атлетик, хөлбөмбөгийн талбайн нээлтийн арга хэмжээ, “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах уулзалт, арга хэмжээ нийт 8 удаагийн төвлөрсөн арга хэмжээ, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Япон, Турк, Солонгос Улсад айлчлах 6 удаагийн гадаад арга хэмжээнд, Монгол

Улсын Их Хурлын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Швейцарын хөгжлийн агентлаг хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсын төлөөллийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд зохион байгуулагдсан “Эмэгтэйчүүд-манлайлал” чуулганд Хурлын эмэгтэй Төлөөлөгчдийг, “Орон нутгийн төсвийг төлөвлөх, хянахад иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын гүйцэтгэх үүрэг”, Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Авлигын эсрэг хөтөлбөрт сургалт” сэдэвт сургалтуудад тус тус Хурлын Төлөөлөгчдийг хамруулан ажиллалаа.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дүрэмд заасны дагуу 7 Төлөөлөгчийн эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлж, 5 Төлөөлөгчид буцалтгүй мөнгөн тусламж олгосон байна.

Тайлант онд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд суудал бүхий Монгол Ардын намын 30 төлөөлөгч, Ардчилсан намын 5 төлөөлөгчдийн Намын суудлын мөнгийг харьяалах намын хороодод, Хурлын Төлөөлөгчдийн урамшууллыг Төлөөлөгчдийн тойрогтоо ажилласан байдлыг харгалзан Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр улирал тутам, Хурлын Тэргүүлэгчдийн урамшууллыг сар тутам, Хурлын хороодын үйл ажиллагааны зардлыг тухай бүр тус тус Хурлын төсвөөс санхүүжүүлж ажиллалаа.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас дэвшүүлсэн зорилт, Хурлын байгууллагын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, иргэдийнхээ хөгжлийг дэмжих хүрээнд иргэд, олон нийтэд чиглэсэн, үр дүн бүхий сургалт, үйл ажиллагаа, арга хэмжээнд Хурлын Төлөөлөгчдийг хамруулан, хамтран ажиллалаа. Үүнд:

Монгол Улсад Ардчилсан Шинэ Үндсэн хууль батлагдсаны 27 жилийн ойн хүрээнд Үндсэн хуулиа сахин хүндэтгэх, хууль дээдлэх ёсыг төлөвшүүлэх, Үндсэн хуулийн үзэл баримтлалыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах зорилгоор Чингэлтэй дүүргийн харьяат, Үндсэн хууль батлалцсан, тухайн үеийн Ардын Их Хурлын Депутатуудыг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, тус арга хэмжээнд АИХ-ын депутатаар ажиллаж байсан Чингэлтэй дүүргийн харьяат 4 иргэн оролцож, Хурлын дарга, Тэргүүлэгчид, Ажлын албаны удирдлагууд, ажилтан албан хаагчид оролцлоо.

Дээрх үйл ажиллагааны хүрээнд Төрийн байгууллагын тогтолцоо, үйл ажиллагааны үндсэн зарчим, Төр-иргэн хоёрын харилцааны үндэсийг тодорхойлсон Үндсэн хуулийн ач холбогдлын талаар мэдлэг олгох “Үндсэн хуулиа сахин дээдэлье” сэдэвт сургалтыг хороодын Иргэний танхимаар зохион байгуулсан бөгөөд арга хэмжээнд Хурлын 16 Төлөөлөгч, дүүргийн 1024 иргэн хамрагдсан байна.

Улс Төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг тохиолдуулан Чингэлтэй дүүргийн харьяат Улс Төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсэд, тэдний гэр бүл, үр хүүхдүүдэд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг Түвдэнпэлжээлин хийдтэй хамтран зохион байгуулж, хэлмэгдэгсдийн хойдын буянд зориулж 1000 зул өргөн, буяны ном хуруулж, хүндэтгэл үзүүлэн, гарын бэлэг гардууллаа. Тус үйл

ажиллагаанд Улс Төрийн хилс хэрэгт өөрөө хэлмэгдсэн 6 иргэн, хэлмэгдэгсдийн үр хүүхэд, тэдний гэр бүл нийт 90 иргэн оролцлоо.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийг сурталчлан таниулах, байгаль орчныг хамгаалахад Төрийн байгууллага-иргэдийн хамтын оролцооны талаар мэдээлэл өгөх зорилго бүхий “Чингэлтэй бидний хайрхан” үйл ажиллагааг зохион байгуулж, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Тэргүүлэгчид, Төлөөлөгчид, хороодын Иргэдийн Нийтийн Хурлын дарга нар, дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын удирдлагууд, албан хаагчид, дүүргийн 250 гаруй иргэд оролцлоо.

Мөн Байгаль орчноо хамгаалах, нөхөн сэргээх, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, экологийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор Чингэлтэй хайрханы өвөр Тахилтад мод тарих өдөрлөгийг зохион байгуулж Хурлын Төлөөлөгчид, хороодын Иргэдийн Нийтийн Хурлын дарга, Тэргүүлэгчид, Гудамж, байрны нийтийн эрүүлүүд болон Хурлын Ажлын албаны ажилтан албан хаагчид хамрагдлаа.

Нийгмийн даатгалын тухай хууль, сайн дурын даатгал түүний хэрэгцээ шаардлага, ач холбогдлыг сурталчлан таниулах “Даатгал бидний ирээдүй” сургалт, үйл ажиллагааг зохион байгуулж, дүүргийн 140 гаруй иргэд оролцсон байна.

Тус үйл ажиллагааны хүрээнд: Чингэлтэй дүүргийн харьяат 37 иргэний эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг Дэлхийн зөн Олон Улсын байгууллагын Чингэлтэй дүүргийн Хөгжлийн хөтөлбөрөөс, 30 иргэний эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас, 2 иргэний эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг сайн үйлсийн аяны хүрээнд төлж, 22 иргэний 2 жилийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг 1 жилийн шимтгэлийн төлбөрөөр хөнгөлөлтэйгөөр тооцон төлөх боломжийг иргэдэд олгож, эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд үнэ төлбөргүй бүрэн хамруулж, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт, даатгалын төрөл, хэлбэр, хамрах хүрээг тогтоож, даатгалын шимтгэл төлөлтийн хэмжээний талаар иргэдэд мэдээлэл өгөх сургалт, үйл ажиллагааг хороодын Иргэний танхимаар зохион байгууллаа.

Түүнчлэн Эрүүл мэндийн тухай хууль, Төрөөс баримталж буй бодлого, үйл ажиллагааг сурталчлах, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор “Эрүүл иргэн” сургалт, үйл ажиллагааг 3 үе шаттайгаар зохион байгууллаа.

Сургалт, үйл ажиллагааны хүрээнд: Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Төрийн өмчийн 11 цэцэрлэгийн бага бүлгийн 782 хүүхдэд амны хөндийн өвчний эрт илрүүлгийн үзлэг хийж, шүдний өвчлөлийг тэмдэглэн картжуулахаас гадна тэдний эцэг, эх, асран хамгаалагч, багш ажилчдын дунд шүдийг эрүүлжүүлэх, амны хөндийн эрүүл мэндийн талаарх мэдлэг, хандлагыг сайжруулах, дадал бий болгох зөвлөмж сургалтыг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд 620 эцэг, эхийн төлөөлөл хамрагдаж анхан шатны мэдлэг дадлыг эзэмшиж, цэцэрлэгийн 15 багш сургагч багшаар бэлтгэгдлээ.

Мөн Эрүүл мэндийн тухай хууль сурталчлах, Төрөөс баримтлах бодлого үйл ажиллагааны талаарх мэдээлэл өгөх, Халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх, эрүүл амьдрах дадал зуршил төлөвшүүлэх чиглэлээр 11 удаагийн сургалт, 4 удаагийн үйл ажиллагааг хороодын Иргэний танхимаар зохион байгуулж, нийт 610 иргэнийг хамруулсан байна.

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хууль, Төрөөс баримталж буй бодлого, үйл ажиллагааг сурталчлах хүрээнд зохион байгуулагдсан “Эрүүл иргэн” сургалт, үйл ажиллагааны хүрээнд 2076 иргэнд сургалт, мэдээлэл өгч, зарим иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамруулан Төрийн үйлчилгээг үзүүлэн ажиллалаа.

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийг сурталчлан таниулах, хүүхдүүдэд эх оронч сэтгэлгээг төлөвшүүлэх, зорилтот бүлгийн иргэдийг бичиг баримтжуулж, Төрийн үйлчилгээг авах нөхцөл боломжийг бүрдүүлэх хүрээнд “Ёслолтой бүртгэл” үйл ажиллагааг дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэстэй хамтран зохион байгууллаа.

Тус үйл ажиллагааны хүрээнд Монгол Улсын Иргэний андгай өргөх ёслолыг зохион байгуулан Чингэлтэй дүүргийн харьяат 16 насанд хүрсэн 111 иргэнд иргэний үнэмлэхийг ёслол төгөлдөр гардуулан, зорилтот бүлгийн 86 иргэнийг бичиг баримтжуулж, төрийн үйлчилгээг авах нөхцөл боломжийг бүрдүүлэн ажилласан бөгөөд “Би Монгол Улсын иргэн” сэдэвт лекц уншиж, урлагийн тоглолтыг толилуулаа.

Нийгмийн халамжийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан холбогдох дүрэм, журмыг иргэдэд сурталчлах зорилгоор “Хүүхэд бүр тэгш эрхтэй”, “Ахмаддаа тусалъя”, “Халамжийн үйлчилгээг иргэн бүрт”, “Өндөр настны тэтгэвэр”, “Хөдөлмөр амжилтын үндэс”, “Халамж ба иргэн”, “Танд ойрхон Төрийн үйлчилгээ”, “Хөдөлмөр өрхийн хөгжлийн үндэс”, “Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг эхэд тэтгэмж олгох тухай”, “Чингэлтэй дүүргийн 10 дугаар хороонд үйлдвэрлэв” сэдэвт 9 удаагийн сургалт, 3 удаагийн өдөрлөг, үйл ажиллагааг хороодын Иргэний танхимаар зохион байгуулж 532 иргэн хамрагдсан байна.

Мөн дээрх сургалт, үйл ажиллагааны хүрээнд “Сэтгэлийн бэлэг” хүмүүнлэгийн өдөрлөгийг дүүргийн Засаг даргын Тамгын газар, Солонгос Монголын хамтарсан “Жан Ум Монгол” ХХК-тай хамтран зохион байгуулж, зорилтот бүлгийн 3 өрхөд өргөө цагаан гэр, 50 өрхөд хүнсний буцалтгүй тусламжийн бүтээгдэхүүнийг тус тус гардууллаа.

Ахмад настны тухай хууль, дүүрэгт хийгдсэн бүтээн байгуулалтын ажлуудыг сурталчлах, ахмад настны нийгмийн хөгжил, оролцоог дэмжиж, эрх зүйн мэдлэг боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор “Ахмадын эрх зүйн боловсрол” сэдэвт үйл ажиллагааг 1-19 дүгээр хороодын ахмадуудын дунд зохион байгуулсан бөгөөд 136 ахмадын төлөөлөл оролцлоо.

Тус үйл ажиллагааны хүрээнд “Ахмадын эрх зүйн боловсрол” сэдвээр “АХА” танин мэдэхүйн тэмцээнийг 2 үе шаттайгаар зохион байгуулж, хороодын Иргэний танхимаар зохион байгуулсан 19 удаагийн үйл ажиллагаанд 530 ахмад настан хамрагдсан байна.

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас “Бүгд Найрамдах Монгол Улсаа тунхагласан өдөр”, “Үндэсний бахархалын өдөр”-ийг тохиолдуулан уламжлалт аж төрөх ёс, үндэсний өв соёл бахархлаа дээдэлж суралцах, Монгол ёс заншил тусгаар тогтнол, эх оронч үзлийг таниулан сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилго бүхий “Эх орон, тусгаар тогтнолын үнэ цэнэ” үйл ажиллагааг 2 үе шаттайгаар дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Төрийн болон Төрийн бус өмчийн Ерөнхий боловсролын сургуулийн багш, эцэг эхчүүд ахлах ангийн сурагчдын дунд зохион байгууллаа.

Энэхүү үйл ажиллагааг “Эх орон тусгаар тогтнолын үнэ цэнэ” сэдвийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн 10 дугаар ангийн сурагчдын дунд эсээ бичлэгийн уралдаан, 11 дүгээр ангийн сурагчдын дунд илтгэлийн уралдаан, түүх нийгмийн ухааны багш нарын дунд ур чадварын уралдаан, эцэг эхчүүдийн дунд ханын сонингийн уралдаан гэсэн 4 төрлөөр зохион байгуулж, эхний шатанд шалгарсан 48 бүтээлийг танилцуулж, шилдэгүүдийг шалгаруулж, шагнаж урамшууллаа.

Агаарын бохирдлыг бууруулах, түүхий нүүрсний хэрэглээгүй орчныг бүрдүүлэх, “Эко айл өрх”-ийн тоог нэмэгдүүлэх, дэвшилтэт тоног төхөөрөмжийг сурталчлах хүрээнд хороодын гудамж, байрны нийтийн эргүүлүүдийг “Мэдээлэл, инновацийн төв”-ийн үйл ажиллагаатай танилцуулж, 10 удаагийн сургалт, мэдээлэл өгч, 543 нийтийн эргүүлийг хамруулсан байна.

Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны "Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай" 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн 7-19 дүгээр хороодоос сонгогдсон төлөөлөгчид айл өрхүүдэд сайжруулсан түлшний хэрэглээ, түүний үр нөлөө, сайжруулсан түлшийг ашиглах, зуухыг зөв галлах, цэвэрлэх талаарх аюулгүй ажиллагааны зөвлөгөө, угаарын хийнд хордсон тохиолдолд анхны тусламж, үйлчилгээг хэрхэн үзүүлэх талаарх зөвлөмж, сэрэмжүүлгийн материал тараалаа.

Мөн нийтээр тэмдэглэх өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд Олон Улсын Эмэгтэйчүүдийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх “Ээждээ илгээх сэтгэлийн үг” захидлын уралдааныг Ерөнхий боловсролын сургуулийн 11,12 дугаар ангийн сурагчдын дунд 2 үе шаттайгаар зохион байгуулсан бөгөөд Монголын үг урлаачдын нийгэмлэгийн хүмүүнлэгийн лектор Г.Бандицэрэнгийн “Уучлаарай ээжээ” лекцийг танилцууллаа.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Бид сайн сайханд дагуулна” уриан дор соёл урлагаар дамжуулан иргэдийг соён гэгээрүүлэх, амьдралын нийтлэг соёлыг төлөвшүүлэх, үндэсний соёл урлаг, өв, хотын соёлыг сурталчлан таниулах, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх хүрээнд “Чингэлтэй фестиваль 2019” арга хэмжээ

зохион байгуулагдсан бөгөөд тус арга хэмжээнд Хурлын Төлөөлөгчид болон Ажлын албаны албан хаагчид хамрагдлаа.

“Хүүхдийг зодож, шийтгэхгүй байх” Олон Улсын өдрийг тохиолдуулан хүүхдийн бие махбодь, сэтгэл санааны эсрэг шийтгэлийг таслан зогсоох, тэдний эрхийг хамгаалах, эцэг, эх, асран хамгаалагч нарт хүүхэд хүмүүжлийн эерэг аргуудыг сурталчилах зорилго бүхий “Хүүхдээ сонсьё” аяныг өрнүүллээ. Тус арга хэмжээнд дүүргийн хүүхэд багачууд, эцэг, эхийн төлөөлөл, хүүхэдтэй ажилладаг байгууллага, хамт олон, нийгмийн ажилтнууд оролцлоо.

Олон Улсын Ахмадын өдрийг тохиолдуулан “Ахмад настанд ээлтэй байгууллага, иргэн шалгаруулах журам”-ын хүрээнд дүүргийн Ахмадын хороо, Хурлын Ажлын алба хамтарсан бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдаж ахмадын байгууллагаас зохион байгуулж буй ажилд идэвх санаачилгатай оролцож, ахмад настны төлөө чин сэтгэлээсээ хандаж дэмжлэг тусалцаа үзүүлсэн Чингэлтэй дүүргийн 5, 17, 18 дугаар хорооны 3 аж ахуйн нэгж байгууллагыг “Ахмад настанд ээлтэй байгууллага”-аар, эд материалын тусламж үзүүлсэн 2, 4, 6 дугаар хорооны 3 иргэнийг “Ахмад настанд ээлтэй иргэн”-ээр тус тус шалгаруулж шагнаж урамшуулсан байна.

Нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, Ажлын албаны ажилтнуудын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Хангарди-2019” спорт наадам Багануур дүүрэгт зохион байгуулагдсан бөгөөд Нийслэл, дүүргийн 10 багийн 400 гаруй тамирчид сагсан бөмбөг, гар бөмбөг, дартс, ширээний теннис, боулинг гэсэн 5 төрөлд өрсөлдсөнөөс Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын баг тамирчид багийн нэгдсэн дүнгээр III байр эзэлж өргөмжлөл мөнгөн шагналаар шагнуулж, “Хангарди-2020” спорт наадмыг зохион байгуулахаар боллоо.

Мөн бүх нийтийн биеийн тамир, спортыг дэмжих хүрээнд жил бүр зохион байгуулагддаг “Улаанбаатар Марафон Олон Улсын гүйлт”-ийн тэмцээнд Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны ажилтан албан хаагчид оролцлоо.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ирүүлсэн удирдамжийн хүрээнд Монгол Улсын шинэ үндсэн хууль батлагдсан өдрийг угтаж дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нэрэмжит шатар сонирхогчдын “Дүүргийн аварга” шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, тус тэмцээнээс шалгарсан эрэгтэй 6, эмэгтэй 3 шилдэг шатарчдыг Нийслэлийн шатар сонирхогчдын аварга шалгаруулах тэмцээнд оролцуулахаар нэрсийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлээ.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын томоохон зорилтын нэг нь анхан шатны Хурлын байгууллагыг бэхжүүлэх, чадавхжуулах явдал юм.

Дээрх зорилтын хүрээнд Хороодын Иргэдийн Нийтийн Хурлын үйл ажиллагааг тогтмолжуулах, Хурлын дарга нарын ажлын уялдаа холбоог

сайжруулах, харилцан мэдээ, мэдээлэл солилцох, арга зүйн сургалтыг 2 удаа, мэдээллийн цагийг 2 удаа, хороодын Иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчдийг чадавхжуулах сургалтыг 1 удаа, 14 дүгээр хорооны нээлттэй өдөрлөгийг тус тус зохион байгууллаа.

Хороодын Иргэдийн Нийтийн Хурлын дарга нарыг ажиллах нөхцөлөөр хангах хүрээнд нутгийн удирдлага сэтгүүл, шаардлагатай сонин хэвлэлийг сар бүр захиалан хүргэж, шаардлагатай зөвлөмж, гарын авлага, бичиг хэргийн хангамжаар тухай бүр ханган ажиллаж байна.

Батлагдсан журмын дагуу Хороодын Иргэдийн Нийтийн Хурлын дарга нарт дэмжлэг үзүүлэх хүрээнд 3 Иргэдийн Нийтийн Хурлын даргыг гадаад арга хэмжээний хөтөлбөрт хамруулж, 2 Хурлын даргын ар гэрт буцалтгүй мөнгөн тусламжийг олгон, ажлын тайлан, мэдээг хагас бүтэн жилээр гаргуулан авч, холбогдох хуулийн дагуу хорооны Засаг даргын үндсэн цалингийн 30 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг сар бүр олгож, дэмжин ажиллаж байна.

Хурлын байгууллагаас Иргэдийн сайн дурын үүсгэл санаачилгын бүлгүүдийн үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллах хүрээнд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, бүтээн байгуулалтын ажлын чанар, гүйцэтгэлд хөндлөнгийн хяналт тавих үүрэг бүхий олон нийтийн хяналтын зөвлөл хороодын Иргэдийн Нийтийн Хурлын даргаар ахлуулан хороо бүрт байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд 2019 онд зохион байгуулах хяналт, шалгалтын ажлын удирдамжийн хүрээнд хийсэн ажлын явцын талаарх мэдээ, санал дүгнэлтийг хагас, бүтэн жилээр гаргуулан ажиллаж байна. Хяналтын зөвлөлийн ажлын үр дүнг харгалзан журмын дагуу зөвлөлийн дарга нарт сар бүрийн мөнгөн урамшууллыг тогтмол олгож, дэмжин ажиллаж байна.

Мөн Иргэний танхимын дэргэдэх залуучуудын клубийн гишүүнчлэлийг нэмэгдүүлж, үйл ажиллагаа, идэвх санаачилгыг дэмжих, залуучуудын нийгэм дэх бодит оролцоог нэмэгдүүлэх хүрээнд 4 чиглэл бүхий “Ирээдүйнхээ төлөө бид оролцъё” 6 сарын хугацаатай болзолт уралдааныг зарлаж, “Тамирчин залуу”, “Өгөх нь авахаасаа илүү ерөөлтэй”, “Бидний дүүрэг-ногоон дүүрэг” сэдвийн хүрээнд бусдыгаа манлайлж ажилласан залуучуудын клубүүдийг шалгаруулж, шагнаж урамшууллаа.

Хороодын “Иргэний танхим”-аар хийгдэх үйл ажиллагааны төлөвлөгөөг тухайн хороодын онцлогт тохируулж, хороодын Иргэдийн Нийтийн Хурлын дарга, Засаг дарга нарын саналыг тусган боловруулан батлуулж, хэрэгжилтийг жигд ханган ажиллахаас гадна Иргэний танхимаар үйлчлүүлж буй иргэдийн тоон мэдээ, өргөдөл, гомдол, санал хүсэлт, цахим хаягт хийсэн тандалтын судалгааг сар тутамд гаргуулан авч, танхимаар дамжуулан зохион байгуулж буй үйл ажиллагаандаа дүн шинжилгээ хийн, үр дүнг тооцон ажиллаж байна.

Тайлант онд хороодын Иргэний танхимаар иргэдээс 620 санал, хүсэлт ирүүлсэнээс цахимаар 293, утсаар 124, биечлэн 164, бичгээр 39 санал, хүсэлтийг хүлээн авч, холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллалаа.

Хороодын Иргэний танхимаар зохион байгуулсан үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах зорилгоор 1-19 дүгээр хорооны Иргэний танхимын нүүр хуудсанд 8257 удаа мэдээ бэлтгэн оруулж, давхардсан тоогоор 118322 хандалт авсан байна.

Тайлант онд хороодын Иргэний танхимаар давхардсан тоогоор 391 удаагийн сургалт, арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд:

Иргэдийн хууль, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр: “Үндсэн хуулиа сахин дээдэлье”, “Иргэний хөгжил-Эрх зүйн боловсрол”, “Галын аюулгүй байдлыг хангах, хяналт шалгалтын мэдээлэл хийх үйл явц”, “Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн ач холбогдол”, “Ахмад настны тухай”, “Шүүхийн Иргэдийн Төлөөлөгчдийн эрх зүйн байдлын тухай” нийт 124 удаагийн сургалтад, давхардсан тоогоор 5499 иргэн хамрагдсан байна.

Иргэдийн эрүүл мэндийг боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндийн зан үйлийг төлөвшүүлэх чиглэлээр: Хороодын Өрхийн эрүүл мэндийн сувилагч нарт “Сувилахуйн түүх хөтлөх”, “Яаралтай тусламж эрэмбэлэн ангилалт” сэдэвт сургалтуудыг, иргэдэд “Хоолны хордлогоос урьдчилан сэргийлье”, “Эрүүл эмэгтэй-Үндэсний баялаг”, Эрүүл мэндийн анхан шатны сургалт, үзлэг, оношилгоо зэрэг нийт 65 удаагийн сургалтад давхардсан тоогоор 2293 иргэн хамрагдсан байна.

Хүний чадварыг дэмжих, хөгжүүлэх чиглэлээр: Байгууллагын менежерүүдэд “Жендер ба бодлого төлөвлөлт” чадваржуулах сургалтыг, иргэдэд “Цахим хэрэглээг соёлтой хэрэглэх шаардлага”, “Манлайлал ур чадвар”, “Гэр бүлийн баяр хөөр”, “Өрхийн санхүүгээ удирдах нь” сэдэвт нийт 179 удаагийн сургалт, үйл ажиллагаа зохион байгуулж, давхардсан тоогоор 5212 иргэн хамрагдсан байна.

Иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх, байгаль орчныг хамгаалах чиглэлээр: Иргэдэд “Гамшгаас хамгаалах нь”, “Гамшигт тэсвэртэй хот судалгаа”, “Сармис хэрхэн тарьж ургуулах вэ?”, “Мод, бут, сөөг тарьж ургуулах, арчлах арга”, “Дотоод орчны агаарын бохирдол”, “Айл өрхийн галын аюулгүй байдлыг хангах”, Шар усны үерт автсан иргэдэд мэдээлэл өгөх болон Гамшиг, ослоос хамгаалах мэдлэг олгох сургалт зэрэг нийт 23 удаагийн сургалтад давхардсан тоогоор 694 иргэн хамрагдсан байна.

Түүнчлэн Иргэний танхимын үйл ажиллагааг иргэд жигд хүргэх зорилготой тогтмол үйл ажиллагааны хуваарийн дагуу долоо хоног бүрийн тогтмол өдрүүдэд зохион байгуулдаг бөгөөд давхардсан тоогоор 5467 иргэн үйлчлүүлж, иргэдэд Төрийн үйлчилгээг жигд хүргэн ажиллаж байна.

Иргэний танхимын үйл ажиллагааг нээлттэй, ил тод, эрх тэгш байх зарчимд тулгуурлан иргэдтэй хийх 161 удаагийн уулзалтад 8713 иргэн, 133 удаагийн хуралд

6203 иргэн, 4 удаагийн хэлэлцүүлэгт 119 иргэн, 278 удаагийн өдөрлөг, үйлчилгээнд 42011 иргэн, 21 удаагийн тэмцээн уралдаанд 1151 иргэн тус тус хамрагдсан байна.

Тайлангийн хугацаанд хороодын Иргэний танхимаар зохион байгуулсан 2225 удаагийн сургалт, үйл ажиллагаанд давхардсан тоогоор 77362 иргэн хамрагдсан байна.

Хурлын Тэргүүлэгчдийн Ажлын алба нь Хурал, Тэргүүлэгчдийн бодлогын зорилтыг зохион байгуулах, Хурлын хороодын хуралдааны бэлтгэл ажил, хуралдаанаас гарах шийдвэрийн төслийг боловсруулан батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих, Хурлын Төлөөлөгчдийн хуралдаа ажиллах нөхцөл бололцоог хангах, техник зохион байгуулалт, арга зүйн туслалцаа үзүүлэх, Хурал, Тэргүүлэгчдээс зохион байгуулсан ажлыг иргэд олон нийтэд сурталчлах, төвлөрсөн болон хяналт шалгалтын бусад арга хэмжээг зохион байгуулах, Хурлын байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналт, төсөв санхүүгийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах чиг үүргийн дагуу ажиллаж байна.

Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас тавьсан санал хүсэлт, өргөдөл гомдлыг шийдвэрлэх, гарсан шийдвэрийн хариуг шуурхай хүргүүлэх замаар эргэх холбоотой ажиллах, чирэгдэлгүй Төрийн үйлчилгээг үзүүлэх зорилтын хүрээнд тайлант онд Хурал, Тэргүүлэгчид түүний Ажлын албанд байгууллага, иргэдээс <https://edoc.ulaanbaatar.mn/> цахим сайтаар ирүүлсэн нийт 248 бичиг хүлээн авснаас 239 бичгийг буюу 96,3 хувийг хугацаандаа шийдвэрлэж, 9 бичгийг судалж байна. Түүнчлэн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд 374 бичиг тоотыг хүргүүлэн ажиллалаа.

Ирсэн бичгийг ангилбал:

- Дээд газраас - 37
- Дүүргийн ИТХ-ын Төлөөлөгч, ИНХ-аас - 5
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, хэрэгжүүлэгч агентлагаас - 36
- Дүүргийн Засаг дарга түүний Тамгын газраас - 155
- Аж ахуйн нэгж, Төрийн бус байгууллагаас – 15

Тайлант онд Хурал, Тэргүүлэгчид түүний Ажлын албанд байгууллага, иргэдээс <http://www.smartcity.mn/> цахим сайтаар 19 өргөдөл, 25 хүсэлт, 1 санал ирүүлсэнийг хүлээн авч, удирдлагуудад шуурхай танилцуулж, 1 өргөдлийг Хурлын Ажлын алба бүрэн шийдвэрлэж, 1 санал, 43 өргөдөл, хүсэлтийг Засаг дарга түүний Тамгын газарт шилжүүлснээс 36 өргөдөл, хүсэлтийн холбогдох арга хэмжээг авч шийдвэрлэн, 1 санал, 7 өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэх шатандаа байна.

Өргөдөл, гомдлыг ангилвал:

- Мөнгөн тусламж хүссэн өргөдөл-19
- Ажлын байр хүссэн хүсэлт- 9
- Төрийн үйлчилгээ хүссэн хүсэлт-12
- Эрх зөвшөөрөл хүссэн хүсэлт-4
- Тохижилт үйлчилгээтэй холбоотой санал-1 байна.

Дүүрэг орон нутгаа хөгжүүлэх санал, санаачилга гаргагчдыг дэмжин урамшуулах зорилтын хүрээнд Хурлын Тэргүүлэгчид Төрийн дээд шагнал, цол, одон, медиалаар шагнуулахаар байгууллага, иргэдээс ирүүлсэн Чингэлтэй дүүргийн харьяат 328 иргэн, “Алдарт эх” 1, 2 дугаар зэргийн одонгоор шагнуулахаар болзол хангасан Чингэлтэй дүүргийн харьяат 417 эхийн тодорхойлолт материалыг тус тус хэлэлцэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд дэмжин уламжиллаа.

Мөн дүүргийн хөгжилд бодитой хувь нэмрээ оруулан, идэвх санаачилгатай ажиллаж байгаа Чингэлтэй дүүргийн харьяат 424 иргэний тодорхойлолт материалтай танилцаж 302 иргэнийг Хурлын дээд шагнал “Чандмань одон”-оор, 122 иргэнийг “Хүндэт өргөмжлөл”-өөр тус тус шагнаж урамшуулахаас гадна 7 иргэнийг дүүргийн “Хүндэт иргэн”-ээр шалгаруулан, батламжиллаа.

Тайланд онд Хурлын дарга Хурлын Ажлын албаны үйл ажиллагаатай холбогдолтой асуудлаар 33 захирамж, Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга үндсэн үйл ажиллагаатай холбоотой 123, боловсон хүчинтэй холбоотой 148, нийт 271 тушаал, шийдвэрийг баталж, хэрэгжилтийг зохион байгууллаа.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2014 оны 01 дүгээр захирамжийн хүрээнд Төсвийн шууд захирагчийн шийдвэрээр нийт 673 зарлагын гүйлгээг анхан шатны баримт бичгийн бүрдэлд үндэслэн хийж гүйцэтгэн, мэдээ, тайланг холбогдох байгууллагуудад цаг хугацаанд нь хүргүүлж, санхүүгийн сар, улирлын мэдээ тайланг нийтэд ил тод байршуулж, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Мөн Нийслэлийн аудитын газраас байгууллагын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн баримтыг холбогдох хууль, Сангийн яамны сайдын баталсан загвар, журам, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв илэрхийлэгдсэн гэж дүгнэн “Зөрчилгүй, санал, дүгнэлт” үнэлгээ авч ажилласан байна.

Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн Улсын үзлэгийн бэлтгэл хангах хүрээнд байгууллагын 1992-2018 он хүртэлх түүхчилсэн лавлагааг хийж, Архив, бичиг хэргийн ажилтнуудыг мэргэжлийн сургалтад хамруулан, архивын өрөөг стандартын шаардлагад нийцүүлэн засч тохижуулан, удирдамжид заасан 4 үзүүлэлтийн дагуух ажлуудыг зохион байгуулж, Улсын үзлэгийн нийт дүнгээр дүүргүүдийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлуудаас хамгийн өндөр оноо буюу 95,5 хувь “А” үнэлгээ авч, манлайлан ажиллалаа.

Шашин сүм хийдтэй харилцах чиглэлээр дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй нийт 36 шашны байгууллагаас 11 нь буддын шашин, 25 нь христийн шашны үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд дээрх байгууллагаас үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгуулахыг хүссэн 12 өргөдөл, хүсэлт ирүүлснийг судлан үзэж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд дэмжиж уламжиллаа.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлж, нутгийн өөрөө удирдах байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах хүрээнд: Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах төлөвлөгөө боловсруулан батлуулж, оны эхнээс хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Тайлант онд Төрийн албаны тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны ажлын байранд шинжилгээ хийж, албан тушаалын тодорхойлолт болон Ажлын албаны хөдөлмөрийн дотоод журмыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, шийдвэрт үндэслэн шинэчлэн боловсрууллаа.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанд орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэлийн хүрээнд нийт 43 албан хаагч ажиллаж байгаагаас Төрийн захиргааны 32, Төрийн үйлчилгээний 4, Улс төрийн 7 албан хаагчтай тус тус гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна.

Тайлант онд 2 албан хаагчийг түр, 6 албан хаагчийг өөрийнх нь хүсэлтээр үүрэгт ажлаас нь тус тус чөлөөлж, 1 албан хаагчийг сэлгүүлэн, 2 албан хаагчийг бүр, 1 албан хаагчийг түр орлон гүйцэтгэгчээр тус тус томиллоо.

Түүнчлэн 3 албан хаагчид Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, 1 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулан олгож, 20 албан хаагчийн цалингийн шатлалыг тус тус ахиулж, 3 албан хаагчийн нийгмийн асуудлыг судлан шийдвэрлэж, 11 албан хаагчид нэг удаагийн буцалтгүй мөнгөн тусламж олгож, 2 албан хаагчийг богино хугацааны гэрчилгээний сургалтад, 7 албан хаагчийг гадаад арга хэмжээний хөтөлбөрт тус тус хамруулж, 40 албан хаагчийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогоонд бүрэн хамрууллаа.

Төрийн албан хаагчдыг чадавхжуулах, ажлын бүтээмжийг дээшлүүлэх, ажилтан, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх хүрээнд “Байгууллагын соёл, багийн ажиллагаа, харилцаа хандлага, ёс зүй”, “Төрийн албаны эрх зүйн шинэчлэл”, “Архив, албан хэрэг хөтлөлт”, “Нийтийн удирдлага” сэдэвт 4 удаагийн нэгдсэн сургалт, Улс, Нийслэл, дүүрэг орон нутаг, Төр захиргааны байгууллагаас өгөгдсөн үүрэг даалгавар, хэрэгжүүлж буй арга хэмжээ, цаг үеийн асуудлаар мэдээлэл хүргэх, үүрэг чиглэл өгөх шуурхай зөвлөгөөнийг 14 хоног тутамд зохион байгуулж хэвшлээ.

Тайлант хугацаанд Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах төлөвлөгөөнд тусгагдсан 22 ажлаас 21 ажлыг бүрэн хэрэгжүүлж, биелэлт 95,4 хувьтай байна.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас чиг үүргийнхээ хүрээнд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл боловсруулан батлуулж,

хэрэгжилтийг зохион байгуулах хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгууллаа. Үүнд:

Хурлын Тэргүүлэгчид түүний Ажлын албанаас зохион байгуулсан үйл ажиллагааны талаар хэвлэл, мэдээллийн бүхий л сувгаар олон нийтэд бодитой, шуурхай, өргөн мэдээллийг тогтмол өгч ажиллах зорилгоор “Хэвлэл мэдээлэл, мэдээллийн ил тод байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө” боловсруулан батлуулж, оны эхнээс хэрэгжилтийг зохион байгуулан ажиллалаа.

Хурлын байгууллагаас баталсан бодлого, шийдвэр, зорилтоо иргэдэд шуурхай хүргэх, сурталчлах зорилгоор хэвлэл мэдээллийн SBN, MNC телевиз, HDV студи, www.MEDEE.MN, www.ZINDAA.MN, www.ZUV.MN сайтууд болон Өнөөдөр, Өдрийн сонин, Зууны мэдээ, Өглөөний сонингуудтай тус тус хамтын ажиллагааны гэрээ байгуулан, үйл ажиллагаагаа сурталчлан, ажиллаж байна.

Тайлант онд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүүгийн нээлттэй ил, тод байдлыг ханган Хурал, Тэргүүлэгчдээс баталсан тогтоол шийдвэр, түүний хэрэгжилт, зохион байгуулсан үйл ажиллагаа болон цаг үеийн бусад 160 удаагийн мэдээ, мэдээллийг бэлтгэн www.chingelteicouncil.mn, www.chingeltei.ub.khural.mn цахим хуудас, олон нийтийн сүлжээ, мэдээллийн самбараар дамжуулан иргэд олон нийтэд сурталчилсан бөгөөд www.chingelteicouncil.mn цахим хуудсанд давхардсан тоогоор 278501, www.chingeltei.ub.khural.mn, цахим хуудсанд 71342 хэрэглэгч хандаж мэдээлэл авсан байна.

Түүнчлэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан мэдээ мэдээллийг SBN телевизээр 8, MNC телевизээр 6 удаа, www.ZUV.MN болон www.news.zindaa.mn сайтуудаар тус бүр - 10 удаа, өдөр тутмын Өнөөдөр, Зууны мэдээ сонингуудаар – тус бүр 2, Өглөөний сонин болон Өдрийн сонинуудаар тус бүр 1 удаа иргэд, олон нийтэд бодитой, шуурхай хүргэж ажилласан байна. Мөн гэрээт “HDV” студиэр ИТХ-ын Тэргүүлэгчид болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хуралдааныг тус тус 1 удаа бэлтгэсэн байна.

Байгууллагын Хэвлэл мэдээлэл, мэдээллийн ил тод байдлыг хангах хүрээнд 36 ажил зохион байгуулахаас 35 ажлыг бүрэн хэрэгжүүлж, төлөвлөгөөний биелэлт 97,2 хувьтай хангагдсан байна.

Мөн дүүргийн гадаад, дотоод харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, үр өгөөжтэй, нэгдмэл байх зарчмыг хэрэгжүүлэх, ижил төстэй байгууллагуудын ажлын туршлагыг судалж өөрийн ажилдаа нэвтрүүлэх хүрээнд “Гадаад дотоод хамтын ажиллагааны төлөвлөгөө” боловсруулан хэрэгжилтийг оны эхнээс зохион байгууллаа.

Тус төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд хамтын харилцаа бүхий БНХАУ-ын Манжуур хот, Эрээн хот, Хайлаар хот, БНСУ-ын Сөүл Хотын Сунпа дүүрэг, Сувон хот, Инчон хотын Сонгбук, Гэяан дүүргүүд, Япон Улсын Токио,

Кавасаки хотууд, БНТУ-ын Анкара хотын Синжан, Анаталия хотын Кемер, Истанбул хотын Пендик дүүргүүдтэй захидал, цахим шуудангаар байнгын харилцаатай ажиллаж байна.

Тайлант онд дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч Л.Ариунтуяа тэргүүтэй 11 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Япон Улсын Токио, Кавасаки хотуудад, Хурлын Тэргүүлэгч Х.Алтаншагай тэргүүтэй 2 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Манжуур хотод, Хурлын Тэргүүлэгч Л.Баярсайхан тэргүүтэй 11 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Бүгд Найрамдах Турк Улсын Истанбул хотын Пендик дүүрэгт, Хурлын Тэргүүлэгч Б.Батхуяг тэргүүтэй 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Бүгд Найрамдах Солонгос Улсын Кёнги аймгийн Сувон хотод, Хурлын Тэргүүлэгч Ц.Дуламжав тэргүүтэй 10 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Инчон хотын Гэяан дүүрэгт, Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны даргаар ахлуулсан 3 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Сөүл хотын Сунпа дүүрэгт тус тус ажлын айлчлал хийж, Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хайку хотод “Иргэдийг гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн аюулгүй байдал” сэдэвт сургалтад хамрагдсан байна.

Айлчлалын үр дүнд Япон Улсын Токио, Кавасаки хотуудтай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, камержуулалт, гэрэлтүүлэг, иргэдийн оролцоог хангах чиглэлээр хамтран ажиллах, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Манжуур хотод Чингэлтэйд үйлдвэрлэв-3 төвийг нээн ажиллуулах, Бүгд Найрамдах Турк Улсын Истанбул хотын Пендик дүүрэгтэй эко байгаль орчны нөхөн сэргээлтийн чиглэлээр туршлага судлах, сайн туршлагыг нэвтрүүлэх хүрээнд, Бүгд Найрамдах Солонгос Улсын Кёнги аймгийн Сувон хоттой хамтын ажиллагаа тогтоох, ойн бүсийн хөгжлийн талаах туршлага судлах, Инчон хотын Гэяан дүүрэгтэй хот тохижилт, ногоон байгууламж, дэвшилтэт техник, технологи болон гадна орчны эрүүл, аюулгүй байдлыг бүрдүүлэхэд иргэд, олон нийтийн оролцоог хангах чиглэлээр, Сөүл хотын Сунпа дүүрэгтэй хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, бага насны хүүхдийг гамшиг ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр тус тус яриа хэлэлцээрийг хийлээ.

Түүнчлэн Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Эрээн хотын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын хорооны орлогч дарга Дү Жиефэн тэргүүтэй 5 хүний бүрэлдэхүүнтэй зочид төлөөлөгчид, Манжуур хотын Хөлөнбуйр аймгийн Аялал жуулчлалын группын дарга Ван Ян Ниан тэргүүтэй 3 хүний бүрэлдэхүүнтэй зочид төлөөлөгчид, Ордос хотын өмнөд хошууны үндэстний ажил мэргэжлийн дээд зэрэглэлийн дунд сургуулийн захирал На Наянтай тэргүүтэй зочид төлөөлөгчид, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Хочимин хотын Тхү Дүк дүүргийн Ардын хорооны дарга Данг Нгуен Тхань Минь тэргүүтэй зочид төлөөлөгчид, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бээжин хотын Шичөн дүүргийн орлогч дарга Ли И тэргүүтэй 6 хүний бүрэлдэхүүнтэй зочид төлөөлөгчдийг тус тус Чингэлтэй дүүрэгт хүлээн авлаа.

Дотоод томилолт, арга хэмжээний хүрээнд: Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга тэргүүтэй 28 зочид төлөөлөгчид, Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга тэргүүтэй 25 хүний бүрэлдэхүүнтэй зочид төлөөлөгчид, Увс аймгийн Баруунтуруун сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга тэргүүтэй 18 хүний бүрэлдэхүүнтэй зочид төлөөлөгчид, Дундговь аймгийн Өлзийт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга тэргүүтэй 9 хүний бүрэлдэхүүнтэй зочид, төлөөлөгчид, Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга тэргүүтэй 30 хүний бүрэлдэхүүнтэй зочид төлөөлөгчид болон Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид Төрийн захиргааны зарим байгууллагуудын удирдах албан тушаалтнууд, Налайх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны албан хаагчдыг Чингэлтэй дүүрэгт хүлээн авч, харилцан туршлага солилцлоо.

Тайлант хугацаанд гадаад дотоод хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулах 15 ажлаас 13 ажлыг зохион байгуулж, биелэлт 86,6 хувьтай байна.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах хүрээнд:

Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон Хурал, Тэргүүлэгчдээс дэвшүүлсэн зорилтын хүрээнд Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Авлигын эсрэг үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлант онд төлөвлөгөөнд тусгагдсан 20 ажил үйлчилгээнээс 20 ажил үйлчилгээг бүрэн хэрэгжүүлж, биелэлт 100 хувьтай байна. Мөн Хурлын Төлөөлөгч, Хурлын Ажлын албаны ажилтан, дүүрэг, хороодын Засаг дарга нийт 44 албан тушаалтны хөрөнгө орлогын 2018 оны мэдүүлгийг цахимаар хүлээн авч, бүртгэл, тайланг хуулийн хугацаанд хүргүүлж ажиллалаа.

Дүүргийн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссын 2019 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган, төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай байна.

Тайлант хугацаанд 17 иргэнд нөхөн олговор олгохтой холбоотой асуудлаар мэдээлэл өгч, 14 иргэний өргөдөл, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэн, холбогдох баримт материалд түшиглэн мэдээллийн санд бүртгэн, бүртгэл судалгааг жил тутамд шинэчлэн боловсруулж байна.

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас нутаг дэвсгэрийн хэмжээнд нийгмийн дэг журмыг хангуулах, хүн амын эрүүл, аюулгүй орчинд амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, иргэдийг соён гэгээрүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд бүх нийтийн оролцоог бий болгох, хамтран ажиллах зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

Дээрх зорилтын хүрээнд дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 2019 онд хэрэгжүүлэх 4 бүлэг, 32 зүйл бүхий төлөвлөгөөний төсөл боловсруулан зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл 13 удаа хуралдаж, 80 асуудлыг хэлэлцэн, 80 тогтоолыг батлан хэрэгжилтийг ханган ажилласнаас гадна байгууллага, иргэдээс 26 бичгийг хүлээн авч, 21 бичгийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.

Тайлант онд дүүргийн хэмжээнд “Сар шинэ” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, мал махан бүтээгдэхүүн тээвэрлэсэн тээврийн хэрэгсэлд тогтмол цагийн хуваарийн дагуу төлөвлөгөөт бус хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллалаа.

Түүнчлэн Ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрх зүйн мэдлэг, мэргэжлийн чиг баримжаа олгох үүрэг бүхий “Өсвөрийн сэргийлэгч бүлгэм”-ийн 2 дугаар чуулган, “Өсвөрийн сэргийлэгч-2019”, “Дэвжээ” тэмцээнүүдийг тус тус зохион байгуулж, ерөнхий боловсролын 4 сургуулийн 44 сурагчийг сэргийлэгчийн иж бүрэн дүрэмт хувцсаар хангалаа.

Мөн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд эцэг, эхчүүдийг татан оролцуулах, тэдний үүрэг, оролцоо хариуцлагыг нэмэгдүүлэх “Хүүхэд хамгаалалд эцэг, эхийн оролцоо” өдөрлөгийг зохион байгууллаа.

Дүүргийн нутаг дэвсгэрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлэх, шинэ техник технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх зорилгоор “Хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд дэвшилтэд техник технологийг ашиглах нь” сэдэвт зөвлөгөөнийг зохион байгуулж, холбогдох албаны хүмүүс болон аж ахуйн нэгж байгууллагуудын төлөөлөл оролцож, санал хүсэлтээ солилцлоо.

Мөн Хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн шинжтэй мэдээллийг иргэд, байгууллагаас төлбөртэй авах ажлыг сурталчлах сурталчилгааны материал хэвлүүлэхээс гадна төлбөртэй мэдээлэл авахад шаардагдах зардлыг дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс санхүүжүүллээ.

Дүүргийн нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хүүхдийг зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэхэд эцэг эх, асран хамгаалагч, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг оролцоог нэмэгдүүлэх, тэдгээрийн хамтын уялдаа холбоог сайжруулах зорилгоор “Хүүхдээ хамгаалъя” хэлэлцүүлгийг, дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох, замын хөдөлгөөнд аюулгүй оролцох дадал эзэмшүүлэх “Ногоон гэрэл-Цагаан шугам 2019” тэмцээн тус тус зохион байгуулж, “Яараад яахав дээ” аянд

нэгдэн зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх санамж, сэрэмжлүүлэг бүхий сурталчилгааны материалыг хэвлүүлэхэд дэмжлэг үзүүллээ.

Цагдаагийн ерөнхий газраас хэрэгжүүлж буй “Нэг хором” нэгдсэн арга хэмжээний хүрээнд дүүргийн 10-19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт архи, согтууруулах ундаагаар үйлчилдэг аж ахуйн нэгж байгууллагуудад зурагт хуудас, сурталчилгааны материалыг болон хар тамхи, архи, цахим тоглоомоос урьдчилан сэргийлэх зөвлөмж, сэрэмжлүүлэг бүхий гарын авлагыг хэвлүүлэхээс гадна “Архигүй орчин-Эрүүл амьдрал” сургалтыг дүүргийн хэмжээнд зохион байгуулж ажиллалаа.

Мөн дүүргийн нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль, хяналтын байгууллагын үйл ажиллагааг дэмжих, урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг нэмэгдүүлэх зорилгоор Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс, Прокурорын газарт шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүллээ.

Тайлант онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг хангах үйл ажиллагаанд туслах чиг үүрэг бүхий хороодын багийн 86 гишүүн, 639 иргэн гудамж, байрны нийтийн эргүүлээр, 23 иргэн хэв журмын урамшилт эргүүлээр, тус тус ажиллаж байгаа бөгөөд тэдний эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулж, хантааз хувцас хэрэглэлээр ханган ажиллаж байна.

Хороодын Гудамж, байрны нийтийн эргүүл, Хэв журмын урамшилтай эргүүлүүдийн дунд сургалт, спорт өдөрлөгийн нэгдсэн арга хэмжээг Чингэлтэй хайрханы Эрдэмийн задгай театрт зохион байгуулж, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн гишүүд, холбогдох хэлтэс албадын дарга нар, Гудамж байрны нийтийн эргүүл, Хэв журмын урамшилт эргүүл 600 гаруй иргэд оролцлоо.

Түүнчлэн Хороодын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх багууд нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулсан ажлын тайлан мэдээ, үр дүнг сар тутамд дүүргийн ГХУСАЗЗ-д тайлагнан, ажиллаж байна.

Тайлант хугацаанд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс хийж хэрэгжүүлэх 32 ажлаас 32 ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, биелэлт 100 хувьтай байна.

ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН АЖЛЫН АЛБА